

UCS 1102B:2020

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ




Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд
тавигдах ерөнхий шаардлага



ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд
тавигдах ерөнхий шаардлага



ГАРЧИГ

1. Зорилго	1
2. Хамрах ба хэрэглэх хүрээ.....	1
3. Норматив эшлэл.....	1
4. Нэр томъёоны тодорхойлолт	2
5. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага	3
6. Байршил.....	5
7. Эдэлбэр газрын хэмжээ, хамрах хүрээ.....	5
8. Гадна орчны ерөнхий шаардлага.....	7
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын шаардлага.....	8
10. Үерээс хамгаалах, борооны ус зайлуулах байгууламж.....	9
11. Барилгын гол хаалга, гадна довжоо.....	10
12. Явган хүний зам	12
13. Авто зогсоол	14
14. Унадаг дугуйн зам, зогсоол.....	16
15. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт	17
16. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	18
17. Биеийн тамирын талбайд тавигдах ерөнхий шаардлага	20
18. Байгууллагын нэрийн тэмдэг, байршлын мэдээлэл.....	21
19. Барилга байгууламжийн нэрийн бичвэр.....	22
20. Үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэг.....	23
21. Хог хаягдал түр хадгалах цэг.....	25
22. Нийтийн эзэмшлийн зам, талбайн гэрэлтүүлэг.....	26
23. Хяналтын камерын систем.....	27
24. Замын хөдөлгөөний аюулгүй байдал.....	28
25. Гамшгаас хамгаалах арга хэмжээ	31
26. Аж ахуйн бүс.....	33
27. Шалгуур үзүүлэлт	34
Ашигласан материалын жагсаалт.....	35

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 7.1. Эдэлбэр газрын хэмжээ	5
Хүснэгт 7.2. Эдэлбэр газрын хувийн жин, зайн хэмжээ	6
Хүснэгт 7.3. Сургуулийн эдэлбэр газрын хэмжээ /тооцоогоор, м2	7
Хүснэгт 11.1. Дагуу налуугийн хэмжээ	12

Хүснэгт 13.1.	Авто зогсоол хүртэлх зай, зогсоолын багтаамж.....	14
Хүснэгт 13.2.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоолын норматив	15
Хүснэгт 16.1.	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн нэр хамаарах арга зүйн удирдамжийн дугаар	19
Хүснэгт 17.1.	Биеийн тамирын талбайн хэмжээ	21
Хүснэгт 20.1.	Хаягийн иж бүрдэл	24
Хүснэгт 24.1.	Сургуулийн бүсэд суурилуулах авто замын тэмдэг.....	29
Хүснэгт 25.1.	Гал унтраах анхан шатны багаж.....	31
Хүснэгт 26.1.	Аж ахуйн бүсийн талбайн хэмжээ	33

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 5.1.	Сургуулийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө /Жишээ.....	3
Зураг 5.2.	Сургуулийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө өмнө талаас харагдах байдал /Жишээ/	4
Зураг 5.3.	Сургуулийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хойд талаас харагдах байдал /Жишээ/	4
Зураг 7.1.	Сургуулийн бүсийн үйлчлэх хүрээ, норматив хэмжээ	6
Зураг 8.1.	Сургуулийн гадна орчны ерөнхий харагдах байдал	8
Зураг 9.1.	Олон улсын хүртээмжтэй байдал, хөгжлийн бэрхшээл тэмдэг	9
Зураг 10.1.	Нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн төлөвлөлт.....	9
Зураг 10.2.	Үерээс хамгаалах, борооны ус зайлуулах байгууламжийн төлөвлөлт.....	10
Зураг 11.1.	Шат болон бариулын хэмжээ	11
Зураг 11.2.	Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт	11
Зураг 11.3.	Шатны нэмэлт бариулын стандарт	11
Зураг 11.4.	Налуугийн хэмжээ	12
Зураг 12.1	Явган хүний замын стандарт	13
Зураг 13.1.	Гадна авто зогсоолын ерөнхий харагдах байдал.....	14
Зураг 13.2.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зогсоол, хүртээмжтэй зогсоолын хэмжээ.....	15
Зураг 14.1.	Унадаг дугуйн зам	16
Зураг 14.2.	Унадаг дугуйн зогсоолын төлөвлөлт	17
Зураг 15.1.	Ногоон байгууламж бүхий амрах талбай.....	18
Зураг 16.1.	Сургуулийн гадна орчин дахь нийтийн эзэмшлийн эд хөрөнгө	19
Зураг 17.1.	Биеийн тамирын жишиг талбай.....	20
Зураг 18.1.	Байгууллагын нэрийн тэмдэг.....	21
Зураг 18.2.	Байгууллагын мэдээллийн самбар.....	22
Зураг 19.1.	Байгууллагын нэрийн бичвэрийн жишээ.....	23

Зураг 20.1.	Байгууллагын нэрийн тэмдэг, барилгын үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэг.....	24
Зураг 20.2.	Төрийн байгууллагын хаягийн тэмдэг.....	25
Зураг 20.3.	Барилгын үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэг.....	25
Зураг 21.1.	Хог хаягдал цуглуулах цэг	26
Зураг 21.2.	Ангилан ялгах тэмдэг бүхий хогийн сав	26
Зураг 22.1.	Гадна орчны гэрэлтүүлэг	27
Зураг 23.1.	Хяналтын камер тэмдэг	28
Зураг 24.1.	Сургууль орчмын бүсийн замын хөдөлгөөн, тэмдэг тэмдэглэгээ.....	28
Зураг 24.2.	Замын босоо тэмдэг суурилуулах.....	30
Зураг 24.3.	Сургуулийн бүс дэх хурд сааруулагч	31
Зураг 25.1.	Сургуулийн бүсэд байрлах цугларах талбай.....	32
Зураг 25.2.	Түр цугларах аюулгүй талбай тэмдэг, суурилуулах схем	33

ХОТЫН СТАНДАРТЫН УДИРДАМЖ АРГА ЗҮЙН БАРИМТ БИЧИГ НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага

1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь шинээр болон шинэчлэн байгуулах ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт, гадна орчинд тавих ерөнхий шаардлагыг тодорхойлж, орчны аюулгүй байдлыг хангахад оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Ерөнхий боловсролын сургуулийн барилгын байршлыг тогтоох, төлөвлөх, стандартад нийцсэн гадна орчныг бүрдүүлэх, сургууль орчмын бүсэд зам замын байгууламж, авто зогсоол, унадаг дугуйн зогсоол, замын тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч зэргийг төлөвлөх, зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, ашиглах, орчны аюулгүй байдлын хяналт хийх үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт дараах эш татсан барилгын норм ба дүрэм, стандартыг хэрэглэнэ. Эш татсан дараах баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ.

- 1.1. БНБД 3.01.06-90 Барилгын орчны тохижилт
- 1.2. БНБД 30-01-04 Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм
- 1.3. БНБД 32-04-06 Хот тосгоны гудамж, зам төлөвлөлт
- 1.4. БД 31-111-11 Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт
- 1.5. БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм
- 1.6. ЗЗБНБД 31-008-2016 Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага
- 1.7. БД 43-101-03 Монгол улсын цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм
- 1.8. БД 30-102-11 Хот тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх
- 1.9. MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
- 1.10. MNS 6444:2014 Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага
- 1.11. MNS 4597:2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
- 1.12. MNS 4759:2014 Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага
- 1.13. MNS 5342 : 2007 Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага
- 1.14. MNS 6808:2019 Явган хүний зам талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага

4. НЭР ТОМЬЁО ТОДОРХОЙЛОЛТ

Сургуулийн гадна орчин гэж суралцагчийн суралцах, хөгжих, хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлж, стандартын дагуу байгуулсан, тоглоом, биеийн тамир, туршилтын болон задгай талбай, ногоон байгууламж, аж ахуйн үйл ажиллагааны бүс бүхий орчныг;

Задгай талбай гэж сургуулийн гадна орчинд байх багш, ажилтан, суралцагчдын арга хэмжээ, уулзалт зохион байгуулах зориулалт бүхий зүлэгжүүлсэн эсвэл цардсан, хөрсний бохирдолгүй талбайг;

Сургуулийн бүс гэж сургуулийн орчмын замд тээврийн хэрэгслийн хурд, хөдөлгөөний журмыг зохицуулах аюулгүй орчныг;

Замын хөдөлгөөний аюулгүй байдал гэж замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн осол, түүнээс үүдэн гарах хор уршгаас хамгаалсан байдлыг;

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах гэж зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгахад чиглэсэн үйл ажиллагааг;

Хурд сааруулагч гэж тодорхой хэсэг газарт замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлэхээс сэргийлэн тухайн бүс нутгийг дайран өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг хязгаарлах зорилгоор суурилагдсан хэрэгслийг;

Теле хяналтын камер гэж оптик хэрэгслийн тусламжтайгаар орчинд алсаас дүрст хяналт хийх зориулалт бүхий төхөөрөмжийг;

Нэрийн бичвэр гэж тухайн хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлсон бичвэрийг;

Хаягийн бичвэр гэж тухайн иргэн хуулийн этгээдийн хаягийг тодорхойлсон бичвэрийг;

Дахивар гэж дахин боловсруулах хог хаягдал буюу шил, лааз, хуванцар, төмөр гэх мэт хоёрдогч түүхий эдийг;

Хогийн савны тэмдэг гэж хогны савны зориулалт, дахиврын төрөл, ангиллыг дүрс, өнгөөр ялгасан тэмдгийг;

Хог хаягдал цуглуулах цэг гэж хүний амьдрах орчин, үйл ажиллагаанаас үүссэн ахуйн хог хаягдлыг цуглуулан бөөгнүүлэх, түр хадгалах зориулалтаар тоноглож, төхөөрөмжлөгдсөн талбай, хашлага, зөвшөөрөгдсөн цэгийг;

Хүртээмжтэй зогсоол гэж хөгжлийн бэрхшээлтэй иргэн, өндөр настан бууж суухад зориулсан авто зогсоолын талбайн зурвасыг;

Хөдөлгөөний хязгаарлалттай хүмүүс гэж ихэвчлэн 60 ба түүнээс дээш өндөр настай хүмүүс, 16 -аас 60 насны хөдөлмөрийн чадвартай бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй, 16 хүртэлх насны тахир дутуу хүүхэд, түр зуурын хөдөлмөрийн чадваргүй, хүүхдийн тэргэнцэр хэрэглэдэг 8 -аас 10 насны хүүхдийг;

Галын аюулгүй байдал гэж учирч болзошгүй гал түймрийн аюулаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин болон нийтийн ашиг сонирхлыг хамгаалсан байдлыг;

5. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА


5.1. Хүүхэд залуу үе сурч боловсрох нөхцөл бүрдүүлэх үүднээс сургуулийн барилга, гаднах орчныг онцгойлон анхаарч төлөвлөнө.

5.2. Сургуулийн бүсийн орон зайг шинээр болон шинэчлэн төлөвлөхдөө цэцэрлэгжилтийн нэгдсэн систем бий болгох, оюун ухаан, бие бялдраа хөгжүүлэх, чөлөөт цагаа

өнгөрүүлэх зэрэг сурагчид, эцэг эх, багш ажилчдын эрүүл аюулгүй орчинд ажиллаж амьдрах нутаг дэвсгэр, архитектур, орон зайн орчин бий болгох асуудлыг иж бүрэн авч үзэх шаардлагатай.

5.3. Ерөнхий боловсролын сургуулийн төлөвлөлтийг хийхдээ нийслэлийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөө, Нийслэлийн урт хугацааны Хөгжлийн Ерөнхий төлөвлөгөө, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн дагуу төлөвлөнө.


5.4. Тусгай хэрэгцээт хүүхдийн ерөнхий боловсролын сургуулийн барилга болон гадна орчны тохижилт төлөвлөлтийг энэхүү баримт бичгийн дагуу төлөвлөх боловч тухайн хүүхдүүдэд зориулсан тусгай хэрэгцээг холбогдох хууль, стандарт, барилгын норм ба дүрмийг баримтална.



Зураг 5.1. Сургуулийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө /Жишээ/



Зураг 5.2. Сургуулийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө өмнө талаас харагдах байдал /Жишээ/



Зураг 5.3. Сургуулийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хойд талаас харагдах байдал /Жишээ/

6. БАЙРШИЛ


- 6.1. Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийг төлөвлөхдөө хот суурины хүн амын нягтаршил, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төслийн дагуу байршлыг тогтооно.
- 6.2. Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламж нь иргэн, олон нийтэд зориулагдсан байх тул суурьшлын бүс, гудамж замын сүлжээ, цэцэрлэгжилт ногоон байгууламжийн бүс, үйлдвэрийн бүстэй аль болохоор зохистой үйлчилгээний хүрээнд байхаар тооцож төлөвлөх шаардлагатай (БНБД 30.01.03, 5.1).

7. ЭДЭЛБЭР ГАЗРЫН ХЭМЖЭЭ

- 7.1. Ерөнхий боловсролын сургуулийн барилга нь тухайлсан эдэлбэр газартай байх бөгөөд эдэлбэр газрын нийт талбайн 50 хувиас багагүй хэсэг нь ногоон байгууламж байхаар төлөвлөх шаардлагатай (БД 31-111-11, 3.6)
- 7.2. Ерөнхий боловсролын сургуулийн эдэлбэр газар нь биеийн тамирын, амралтын, аж ахуйн гэсэн үндсэн бүсүүдэд хуваагдах бөгөөд бүсүүдийг хууль, норм, дүрэм, стандартад зааснаар ноогдох талбайн хэмжээг тооцно (БД 31-111-11, 3-р бүлэг).
- 7.3. Ерөнхий боловсролын сургуулийн барилгын хүчин чадлыг тухайн суурьшлын бүсийн байрлал, үйлчлэх хүрээний хүн амын тоо, сургуулийн насны хүүхдийн насны ангиллаас хамааруулсан тоон судалгаанд үндэслэн тодорхойлно (БД 31-111-11, 1.3.5-1.3.9).
- 7.4. Сурагчийн тооноос хамааруулах нэг сурагчид ногдох эдэлбэр газрын хэмжээг Хүснэгт 7.1-т үзүүлэв (БНБД 30.01.03, 13-р хавсралт).

Хүснэгт 7.1. Эдэлбэр газрын хэмжээ

Ангилал	Сургуульд хамрагдах хувь	Норматив хэмжээ /1000 хүнд/	Үйлчлэх хүрээ	Суралцагчдын тоо	Нэг сурагчид ногдох талбай, м2		
Бүрэн бус дунд боловсрол (I-VIII анги)	100%	200м ²	750 метр	120	50		
				120 - 500	60		
				500 - 800	40		
Дунд боловсрол (IX-X анги)	75%			800 -1100	35		
				1100 -1600	25		
				1600 - 2000	20		
				2000-аас дээш	18		



Зураг 7.1. Сургуулийн бүсийн үйлчлэх хүрээ, норматив хэмжээ

7.5. Ерөнхий боловсролын сургуулийн барилга байгууламжийн эдэлбэр газрын нэг хүнд ноогдох талбай, эдэлбэр газар дахь барилгын хана, цонх хүртэлх зайг Хүснэгт 7.2-т зааснаас ихгүйгээр төлөвлөнө (БНбД 30.01.04, 2.12).

Хүснэгт 7.2. Эдэлбэр газрын хувийн жин, зайн хэмжээ

Талбай	Талбайн хувийн жин m^2 /хүн	Талбайгаас барилга хүртэлх зай /метр/
Тоглох талбай	0.7	12
Амрах талбай	0.1	10
Биеийн тамирын талбай	2.0	10
Аж ахуйн зориулалтын талбай	0.3	20
Авто зогсоолын талбай	0.8	нормоор

Ерөнхий боловсролын сургуулийн хүчин чадалд суурилан сургуулийн эдэлбэр газрын хэмжээг тооцон Хүснэгт 7.3-т тусгаснаар тодорхойлно (БНбД 30.01.04, 2.12), (БНбД 30.01.03, 13-р хавсралт). Талбайн хувийн жинг суралцагчдын тоогоор үржүүлэн тооцоолов. (Зураг 7.1)

Хүснэгт 7.3. Сургуулийн эдэлбэр газрын хэмжээ /тооцоогоор, м2/

Суралцагчдын тоо	Тоглох талбай	Амрах талбай	Биеийн тамирын талбай	Аж ахуйн зориулалтын талбай	Авто зогсоолын талбай	Нийт талбайн хэмжээ
120	84	12	240	36	96	468
120 - 500	350	50	1000	150	400	1950
500 - 800	560	80	1600	240	640	3120
800 -1100	770	110	2200	330	880	4290
1100 -1600	1120	160	3200	480	1280	6240
1600 - 2000	1400	200	4000	600	1600	7800
2000-аас дээш	1400-дээш	200-дээш	4000-дээш	600-дээш	1600-дээш	7800-дээш

7.7 Амралтын бүсийг ногоон байгууламжтай зэрэгцээ аж ахуйн болон биеийн тамирын талбайгаас төлөвлөлтийн боломжоор зайтай төлөвлөх нь ашиглалтад тохиромжтой.

7.8. Биеийн тамирын талбай хүртэлх зайг орчинд нөлөөлөх дуу шуугианы тооцоог үндэслэн тогтоох бөгөөд хогийн савнаас биеийн тамирын, хүүхдийн тоглоомын, амрах талбай хүртэлх зай 20 метрээс багагүй, аж ахуйн зориулалттай талбайгаас 100 метрээс ихгүй байна

8. ГАДНА ОРЧНЫ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

8.1. Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн гадна орчны тохижилтыг төсөллөхдөө норм, дүрэм, стандартын дагуу барьж байгуулах ба орчны аюулгүй байдлыг хангасан байх шаардлагатай.

8.2. Сургуулийн орчмын тохижилтыг хаана, ямар байршилд төлөвлөж байгааг судлан үзэж тухайн орчинд нийцсэн байх шаардлагатай. Жишээлбэл: Орон сууцны бүсэд бол дуу чимээг тооцоолж тохиромжтой байршилд тоглоом болон биеийн тамирын талбайг төлөвлөх.

8.3. Ерөнхий боловсролын сургууль болон сургууль орчмын тохижилтыг шинээр болон шинэчлэн төлөвлөхдөө суралцагчдын эрүүл аюулгүй орчинд сурах нөхцөл бололцоог хангаж, архитектур, орон зайн тухтай орчин бий болгох үүднээс дараах зүйлсийг цогцоор нь төлөвлөж, барилгын ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

8.3.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдал;

8.3.2. Үерээс хамгаалах, борооны ус зайлуулах байгууламж;

8.3.3. Зам, замын байгууламж;

8.3.4. Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж;

8.3.5. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө;

8.3.6. Сургалт, спортын талбай;

8.3.7. Хаяг, хаягжилт, гэрэлтүүлэг чимэглэл;

8.3.8. Хог хаягдлын цэг;

8.3.9. Аюулгүй байдал, гэрэлтүүлэг, камержуулалт;

8.3.10. Сургуулийн эдэлбэр газрын хашаа;

8.3.11. Аж ахуйн зориулалттай бүс;

- 8.4. Явган иргэн болон автотээврийн хэрэгслээр сургуулийн орчинд аюулгүй, ээдрээгүй хүрч очих боломжийг хангасан байх;
- 8.5. Тохижилтын элементүүд нь сургууль, зогсоол, зэргэлдээх гудамж гэх мэт тухайн орчинтойгоо уяалдсан байх;
- 8.6. Тохижилтын элементүүд нь орчиндоо өнгө үзэмж нэмэгдүүлэхээс гадна арчлалт хамгаалалт хийхэд хялбар амар байхаар төлөвлөнө.
- 8.7. Хувийн тээврийн хэрэгсэл болон сургуулийн автобус нь хүүхэд багачуудыг хүргэж өгөх, авах тусдаа зогсоолын талбайтай байх ба энэхүү хэсэг нь бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд, явган хүний замтай зөрчилдөхгүй байхаар төлөвлөх шаардлагатай.
- 8.8. Тээврийн хэрэгслийн орц гарц, чиглэлийг тодорхой заасан байх, сургуулийн автобус, ажилчдын тээврийн хэрэгсэл, үйлчилгээний тээврийн хэрэгслийг орц, гарц, зогсоол тус тусдаа байна.
- 8.9. Сургуулийн гадна орчны тохижилтыг 1600-2000 хүүхэдтэй сургуулийн жишиг загвар болгон тооцсоныг Зураг 8.1-т үзүүлэв.



Зураг 8.1. Сургуулийн гадна орчны ерөнхий харагдах байдал

- 8.10. Ерөнхий боловсролын сургууль барьж байгуулах төслийг боловсруулахдаа Үндэсний стандарт, Барилгын норм ба дүрэм болон Хотын стандартын дагуу төлөвлөж эрх бүхий байгууллагын баталсан ажлын зураг төслийн дагуу гүйцэтгэнэ.

9. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДЛЫН ШААРДЛАГА

- 9.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-т зааснаар “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хамааруулах бөгөөд орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр,

мэдээлэл, харилцаа холбооны технологи нь хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байна.

9.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлж барилга байгууламжид ашиглагддаг олон улсын тэмдэг тэмдэглэгээг Зураг 9.1-т үзүүлсний дагуу хийж байршуулна.



Зураг 9.1. Олон үлсын хүртээмжтэй байдал, хөгжлийн бэрхшээл тэмдэг

10. ҮЕРЭЭС ХАМГААЛАХ, БОРООНЫ УС ЗАЙЛУУЛАХ БАЙГУУЛАМЖ

10.1. Барилга байгууламж, бүх төрлийн зам, замын байгууламж, авто зогсоол, талбай, цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийг барьж байгуулахад холбогдох стандарт, барилгын норм дүрэм, “Үерээс хамгаалах байгууламжийг төлөвлөх удирдамж”-ийг мөрдлөг болгоно.


10.2. Үерийн эрсдэл бүхий газар, голын сав, үерийн усны урсац бүрэлдэх газарт нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулахыг хориглох бөгөөд тус барилга байгууламжийг эрсдэл багтай бүсэд байгуулна (Зураг 10.1).

10.3. Төлөвлөлтийг гүйцэтгэхдээ иргэд болон онцгой байдлын албан хаагчдад учирч болох үерийн эрсдэлийг аюулгүйн хэмжээнд байлгах, барилга байгууламж түүнд холбогдох дэд бүтцэд үерийн хохирол учрахаас сэргийлэх эсвэл болзошгүй эрсдэлийг арилгахаар тооцож төлөвлөнө.



Зураг 10.1. Нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн төлөвлөлт


- 10.4. Төслийн төлөвлөж байгаа талбайд хурсан борооны ус нь ойролцоох болон усны урсгалын доод хэсэгт байрлах барилга байгууламжид нөлөөлөхгүй байх ёстой.
- 10.5. Барилга, зам, талбайн үерээс хамгаалах болон борооны ус зайлуулах дэд бүтэц барьж байгуулах нь эцсийн шийдэл биш бөгөөд тасралтгүй шинэчлэлт хөгжүүлэлт, тогтмол арчилгаа, засвар үйлчилгээ хийх шаардлагатай.
- 10.6. Аливаа барилгажилтын үйл ажиллагаа нь үерийн нөлөөллийг эрчимжүүлэх ёсгүй бөгөөд төсөл төлөвлөх нутаг дэвсгэрийн үнэлгээний хүрээ, арга технологийг тогтоож, үерийн гамшигт автах эрсдэлийг бууруулж борооны ус зайлуулах байгууламжийг төлөвлөнө (Зураг 10.2).



Зураг 10.2. Үерээс хамгаалах, борооны ус зайлуулах байгууламжийн төлөвлөлт


11. БАРИЛГЫН ГОЛ ХААЛГА, ГАДНА ДОВЖОО

- 11.1. Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гол хаалга болон гадна довжоог шинээр хийх болон шинэчлэх ажилд «Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин» MNS 6055 болон “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүй” UCS 1001A -ийг мөрдлөг болгоно.
- 11.2. Барилгын гол хаалга нь олоход хялбар, шинээр баригдах барилгын бүх орц хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй иргэн саадгүй нэвтрэх боломжтой байх ёстой. Хуучин барилгын ядаж гол орох хаалга нь дээрх шаардлагыг хангасан байх ёстой.
- 11.3. Гол хаалга нь тухайн орчны явган хүний зам, авто зам, замын байгууламж, авто зогсоол, бууж суух талбай болон нийтийн тээврийн зогсоолтой холбогдсон байх ба олон давхар барилгад цахилгаан шат уруу нэвтрэх боломжийг бүрдүүлсэн байна.
- 11.4. Барилгын үүдний өрөөний шалны түвшин орц уруу орох явган хүний замын түвшнээс 15 см-ээс багагүй өндөр байх ёстой бөгөөд шатны гишгүүрийн тоо 3-аас багагүй 18-аас ихгүй байна. Гишгүүрийн өргөн 25 см-ээс багагүй, өндөр 15 см-ээс багагүй ба 18 см-ээс ихгүй байна (Зураг 11.1).




Зураг 11.1. Шат болон бариулын хэмжээ

11.5. Барилгад тэргэнцэртэй иргэн хэн нэгний тусламжгүйгээр нэвтрэх боломжийг хангаж шалны хоорондох уналтын зөрүү 4 см-ээс их бол налуу зам хийх ба зам нь 1х12 харьцаа бүхий налуутай байна. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт зай хэмжээ, харагдах байдлыг Зураг 11.2-т үзүүлэв.



Зураг 11.2. Барилгын орц, гадна довжоо, налуу замын стандарт

11.6. Шатны гишгүүр, шатны налуу болон талбайд бариултай хашлага байх ёстой ба өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан шатны нэмэлт бариулыг төлөвлөнө. Шатны бариулын стандарт зай хэмжээг Зураг 11.3-т үзүүлэв.




Зураг 11.3. Шатны нэмэлт бариулын стандарт

- 11.7. Явган хүний замын тодорхой зайнд налуу хэсэг хийх замаар өндөр хувьтай налуу дээрх хөдөлгөөнийг аюулгүй болгож болно. Явган хүний замыг тодорхой уртад 9000 мм интервалаар 6%-8%, 12000 мм интервалаар 5%-6% дагуу налуутай байхаар шаталсан хэлбэрээр төлөвлөнө. Налуу замыг халтирахаас сэргийлсэн барзгар гадаргуутай байхаар төлөвлөнө. Налуу нь 6%-с дээш тохиолдолд бариул нэмэлтээр төлөвлөнө. Явган хүний замын дагуу налуугийн зөвшөөрөгдөх хэмжээг Хүснэгт 11.1, Зураг 11.4-д үзүүлэв.

Хүснэгт 11.1. Дагуу налуугийн хэмжээ


Явган хүний замын дагуу налуу	Дагуу налуугийн урт
6% - 8%	9000 мм (9 м)
5% - 6%	12000 мм (12 м)
4% - 5%	15000 мм (15 м)



Зураг 11.4. Налуугийн хэмжээ

12. ЯВГАН ХҮНИЙ ЗАМ

- 12.1. Гудамж, замын сүлжээг тээврийн хэрэгсэл, дугуйтай ба явган зорчигчийн хөдөлгөөний эрчим, нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, орон зайн зохиомж, орчны барилга байгууламжийн байршил, архитектуртай уялдуулан, тасралтгүй нэгдсэн систем байхаар тооцож төлөвлөнө (БНБД 30.01.04, 6.18).
- 12.2. Ерөнхий боловсролын сургуулийн эдэлбэр газарт байрлах явган хүний зам нь нийтээр эзэмших зам талбай тул явган зорчигчийн аюулгүй байдлыг хангасан байх шаардлагатай. UCS 0901B:2020 стандартад нийцүүлэхээс гадна хүүхдийн орчин, харааны бэрхшээлтэй болон тэргэнцэртэй хүүхэд зорчих нөхцөлийг хангасан байна (Зураг 12.1).




Зураг 1. Явган хүний замын стандарт

12.3. Явган хүний зам төлөвлөхөд дараах нийтлэг зарчмуудыг баримтална. Үүнд:

- 12.3.1. Явган хүний зорчих өргөнийг (барилга байгууламжийн нүүрэн хэсэг, явган хүний зам, ногоон байгууламж) иж бүрэн төлөвлөх ба явган зорчигчдын хөдөлгөөний орон зай хангалттай байна.
 - 12.3.2. Явган хүний замын сүлжээ буюу явган хүний зам нь тасралтгүй үргэлжилсэн байна.
 - 12.3.3. Явган хүний замыг бие даан хөдөлгөөнд оролцох чадвартай явган зорчигчдоос гадна бусдын тусламж, хараа хяналтад явдаг хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчиход саадгүй буюу хүртээмжтэй байна.
 - 12.3.4. Явган зорчигчдын аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлсэн байна.
 - 12.3.5. Чанартай гадаргуутай байна.
 - 12.3.6. Тэмдэг тэмдэглэгээ бүрэн бүтэн, маршрутын самбар ойлгомжтой байна.
- 12.4. Зорчигчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор явган хүний замыг авто тээврийн хэрэгсэл зорчих хэсгээс тусгаарласан хаалт, хашилт, түмбэ суурилуулна.
- 12.5. Сургуулийн бүсэд MNS 6423:2019 стандартын шаардлагыг хангасан байна.

13. АВТО ЗОГСООЛ

- 13.1. Зогсоолыг хот төлөвлөлт, явган хүний болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, автомашины хөдөлгөөний эрчим, зогсоолын эрэлттэй уялдуулан шинээр барих барилга байгууламжийн зураг төсөлд заавал тусгаж, байгуулна (MNS 5342:2007, 4.8).
- 13.2. Ерөнхий боловсролын сургуулийн эдэлбэр газрын аж ахуйн бүсэд тээврийн хэрэгслийн зогсоол төлөвлөнө (БНБД 32-01-04, 6.30). Сургуулийн эдэлбэр газарт байх авто зогсоолын талбайг Зураг 13.1-т үзүүлэв.



Зураг 13.1. Гадна авто зогсоолын ерөнхий харагдах байдал

- 13.3. Ерөнхий боловсролын сургуулийн барилгаас тухайн сургуульд хамааралтай авто зогсоол хүртэлх зайг авто тээврийн хэрэгслийн хүчин чадалтай уялдуулж төлөвлөх нь зүйтэй (БД 31-111-11, 3.2). Зай хэмжээг Хүснэгт 13.1-д үзүүлэв.

Хүснэгт 13.1. Авто зогсоол хүртэлх зай, зогсоолын багтаамж


Зогсоолын багтаамж /тээврийн хэрэгслийн тоо/	Сургуулийн барилга хүртэлх зай /метр/
10	15
11-100	25
101-300	50

- 13.4 Зогсоолын талбай нь MNS 5342:2007 стандарт, БНБД 32-04-06 норм дүрмийн шаардлагын дагуу автомашин тавьж байрлуулахад зориулсан хатуу хучилт бүхий талбай байна (MNS 5025:2020, 8.1).
- 13.5. Зогсоолын орц болон гарц дээр автомашины хурдыг хязгаарлах, явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор хурд сааруулагчийг байрлуулна.
- 13.6. Явган хүний зам руу тээврийн хэрэгсэл нэвтрэх болон явган зорчигчдын хөдөлгөөний зурвасыг тээврийн хэрэгсэл хаахаас урьдчилан сэргийлэхийн тулд явган хүний замаас зогсоолын хэсгийг тусгаарлах хаалт хашилт суурилуулна.
- 13.7. Авто тээврийн хэрэгсэл байрлуулах зогсоолын байрлалыг цагаан зураасаар, аюулгүйн тэмдэглэгээг шар зураасаар стандартын дагуу тус тус тэмдэглэнэ (MNS 5025:2020, 8.3).
- 13.8. Нийгмийн дэд бүтцийн барилга байгууламжийн гадна зогсоолд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоолыг төлөвлөх бөгөөд тухайн зогсоолын хүчин чадлаас хамааруулан Хүснэгт 13.2-д заасны дагуу тооцож төлөвлөнө. (БД 31-112-11, 3.4).

Хүснэгт 13.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоолын норматив

№	Зогсоолын тоо	Нийт зогсоолд эзлэх хувь, зогсоолын тоо
1	100 хүртэл	4% буюу 1 -ээс багагүй
2	101 - 200 хүртэл	3%
3	201 - 1000 хүртэл	2%
4	1000 -аас дээш	100 машин тутамд 1%, нэмж 20 машинаас ихгүй


- 13.9 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тээврийн хэрэгсэл байршуулахад зориулсан зогсоолыг явган хүний гарц болон сургуулийн барилгад ойр байхаар төлөвлөх нь зүйтэй.
- 13.10.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан авто зогсоолыг барилга байгууламжийн гол орц, хаалга хүртэл хамгийн ойр боломжит зайд төлөвлөх бөгөөд зогсоолын талбайд тусгай өнгө бүхий “Тэргэнцэртэй иргэн” замын тэмдэг тэмдэглэлээр ялгасан байна (Зураг 13.2).



Зураг 23.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зогсоол, хүртээмжтэй зогсоолын хэмжээ

14. УНАДАГ ДУГУЙН ЗАМ, ЗОГСООЛ

- 14.1. Унадаг дугуйн замыг хотын оршин суугчдын эрэлт хэрэгцээ, зорчих чиглэл, хөдөлгөөний ачааллыг харгалзан нэгдсэн унадаг дугуйн замын сүлжээ үүсгэж төлөвлөх нь чухал бөгөөд иргэд унадаг дугуйн замаар зорчих боломжийг бий болгох шаардлагатай.
- 14.2. Унадаг дугуйн замыг бусад тээврийн хэрэгсэл зорчих замаас түрүүлж анхааран үзэж төлөвлөх ёстой. UCS 0903B:2020 стандартын шаардлагын дагуу төлөвлөнө.
- 14.3. Унадаг дугуйн замын тэмдэг, тэмдэглэгээ нь MNS 4597:2014 стандартын дагуу хийгдэнэ. Унадаг дугуйн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор тухайн замын төрөл, ангилал, гудамжны хөдөлгөөний нөхцөл байдлаас хамааруулан унадаг дугуйн замын хашилт ба чиглүүлэх хэрэгсэл ашиглаж болно (Зураг 14.1).



Зураг 14.1. Унадаг дугуйн зам

- 14.4. Унадаг дугуйн зорчих хэсгийн өргөн нь нэг эгнээнд хамгийн багадаа 1.5 м байна. Унадаг дугуйн замын хучилт нь Монгол орны цаг уурын нөхцөлд зохицсон, зөөлөн, халтиргаа багатай, тоосгүй, ус нэвтрүүлдэггүй байна.
- 14.5. Унадаг дугуйн замын төлөвлөлтөд унадаг дугуйн байгууламжийг иж бүрнээр нь авч үзэх бөгөөд энэ хүрээнд унадаг дугуйн зогсоолыг төлөвлөгдсөн газруудад барьж байгуулах шаардлагатай. Унадаг дугуйн зогсоолыг ил болон далд, саравчтай байгуулж болох бөгөөд заасан зай хэмжээний шаардлагын дагуу төлөвлөнө (UCS 0903B:2020).
- 14.6. Унадаг дугуйн зогсоолыг ил задгай, саравчтай, мөн битүү байгууламжид байгуулж болох бөгөөд Зураг 14.2-д заасан зай хэмжээний шаардлагыг хангасан байна.



Зураг 14.2. Унадаг дугуйн зогсоолын төлөвлөлт

15. НОГООН БАЙГУУЛАМЖ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ

- 15.1. Хот, тосгоны цэцэрлэгжүүлэлтийг хүн амын ажиллаж амьдрахад тохиромжтой гоо зүй, экологийн нөхцөлийг хангасан хотын орон зайн бичил уур амьсгалын тааламжтай орчныг бий болгож хүний үйл ажиллагааны элдэв хортой нөлөөллөөс хамгаалах, барилгажсан нутаг дэвсгэрийн архитектур орон зайн зохиомжийг сайжруулсан байхаар тооцож төлөвлөнө.




Зураг 15.1. Ногоон байгууламж бүхий амрах талбай

- 15.2. Мод бут сөөг зэрэг ногоон байгууламжийг архитектурын бага хэлбэрийн элементүүд болох сандал, саравч, хөшөө дурсгал, усан оргилуур гэрлийн шон зэрэгтэй зохицуулан ландшафт архитектурын уран шийдэл гарган төлөвлөх нь зохистой.
- 15.3. Сургуулийн гадна орчны ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, амрах талбайн хэмжээг эдэлбэр газарт тогтоосон нормын дагуу төлөвлөх ба сургуулийн сурагчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор өргөсгүй, элдэв хурц үнэргүй мод бут, сөөг ургамлыг сонгон тохижуулна (Зураг 15.1).
- 15.4. Барилгын орчны цэцэрлэгжүүлэлтэд хэрэглэх суулгачын нь өвчин, хортонд нэрвэгдээгүй эрүүл, стандартын шаардлагыг хангасан байвал зохино. Барилгын орчны зам талбайг байгуулж, хайс, хашлагыг байрлуулж, хог хаягдлыг бүрэн цэвэрлэсний дараа цэцэрлэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ (БНБД 3.01.06-90, 6.1)
- 15.5. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг төлөвлөхдөө тухайн байршил, орон нутгийн хөрс, уур амьсгалын нөхцөл, үеийн гүн, тухайн хөрсний үржил шим, цэцэрлэгжүүлэлтэд хэрэглэх мод, ургамлын нэр төрөл, суулгачын материал зэргийг тооцон үзнэ. Хуучин байсан ургамал, ялангуяа мод сөөг, үржил шимт өнгөн хөрсийг аль болохоор хадгалан үлдээнэ.
- 15.6. Модыг барилгын цонхноос 10 м-ийн зайд, бут, сөөгийг 5 м-ээс доошгүй зайтай тарьж суулгана (БНБД 66-88).
- 15.7. Цэцэрлэгжүүлэлтийн зориулалт болон нар, салхины нөлөөлөл, агаарын бохирдолт, хөрсний нөхцөл зэрэг тухайн нөхцөл байдалтай уялдаатайгаар мод, сөөгийн нэр төрөл, тарих хэлбэрийг сонгон авна (БНБД 30-01-04).
- 15.8. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг хийхдээ тухайн орчны болон барилга байгууламжийн загвар, дизайн, өнгө үзэмжид оновчтой тохируулан тохижуулна.
- 15.9. Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтэд хэрэглэх суулгац, зүлэгжүүлэх, ургамалжуулах талбайн хэмжээ болон технологийн бусад тавих шаардлагуудыг холбогдох норм, дүрэм, стандартын шаардлагыг дагуу гүйцэтгэнэ.
- 15.10. Мод, бут сөөгийг сүүдэрлэх, салхины хамгаалалт, гоо зүйн зохицол бий болгох зорилгоор төлөвлөх ба сургуулийн талбайн 7-15% -ийг мод, бут сөөг гэх мэт ургамал тарих зохимжтой (зүлэгт талбайг оруулаагүй).
- 15.11. Гоёлын бут сөөг нь хортон шавьж устгах бодис цацах, хог ургамал устгах гэх мэт арчилгаа их шаарддага тул тохиромжгүй ба зөвхөн гол хаалганы ойролцоо онцлохоор ганц нэгээр тарих нь зохистой.
- 15.12. Мод бут сөөгний титэмийн хэлбэр, холтосны өнгө, цэцэглэлтийн хугацаа, жимс, ялгаруулах үнэр, зэрэг шинж чанар, биологийн онцлогыг харгалзан сургуулийн орчинд тусгайлан бэлтгэсэн талбайд сургалт судалгаа, танин мэдэхүйн зорилгоор төлөвлөж болно.

16. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

- 16.1. Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тав тух, орчны аюулгүй байдал, үндэсний стандарт, барилгын норм ба дүрэм болон хотын стандартын шаардлагад нийцсэн нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг байрлуулж болно.

- 16.2. Хотын гудамж, нийтийн эзэмшлийн зам талбайд байрлуулах нийтийн эзэмшлийн эд хөрөнгө нь тухайн гудамж болон ойролцоо орших барилгын архитектур дизайны онцлогт нийцсэн, өндөр чанартай, нэгэн төрлийн өнгө загвартай байвал зохино.



Зураг 16.1. Сургуулийн гадна орчин дахь нийтийн эзэмшлийн эд хөрөнгө

- 16.3. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө гэдэгт дараах зүйлсийг ойлгох бөгөөд холбогдох Хотын стандарт арга зүйн удирдамжид “Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө” UCS14** -т хамаарах баримт бичгийг мөрдлөг болгоно (Хүснэгт 16.1). Үүнд:

Хүснэгт 16.1. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн нэр хамаарах арга зүйн удирдамжийн дугаар

№	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн нэр	Баримт бичгийн дугаар
1	Нийтийн бие засах газар	UCS 1401B
2	Усан оргилуур	UCS 1402B
3	Хөшөө, архитектурын байгууламж	UCS 1404B
4	Чийрэгжүүлэх төхөөрөмж бүхий талбай	UCS 1403B
5	Хүүхдийн тоглоомын талбай	UCS 1405B
6	Спорт талбай	UCS 1406B
7	Амрах талбай	UCS 1407B
8	Мэдээллийн самбар	UCS 1401C
9	Саравч, сүүдрэвч	UCS 1402C
10	Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн сав	UCS 1403C
11	Сандал	UCS 1404C
12	Хашаа, хайс, хашлага	UCS 1405C

Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд байрлаж байгаа нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн ашиглалтын үйл ажиллагааг “Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байрлуулсан эд хөрөнгийн бүртгэл, ашиглалтын удирдамж” UCS 1401A -ийн дагуу зохион байгуулна.

17. БИЕИЙН ТАМИРЫН ТАЛБАЙД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 17.1. Биеийн тамир, спортын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 5-д ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх стандартын шаардлага хангасан барилга байгууламж, заал, талбайтай байх нөхцөлийг бүрдүүлнэ гэж тусгасны дагуу ерөнхий боловсролын болон тусгай боловсролын сургууль нь гадна орчиндоо биеийн тамирын талбайг төлөвлөнө.
- 17.2. Манай оронд түгээмэл хөгжиж буй спортын төрлүүдээр MNS 5420-18:2004 стандартад тусгасан мэдлэг ур чадварыг эзэмшүүлэхийн тулд дараах төрлийн спортын талбай, хэрэглэгдэхүүнээр гадна орчныг тохижуулж болно (Зураг 17.1). Үүнд:
- 17.2.1. Хөл бөмбөгийн талбай
 - 17.2.2. Чийрэгжүүлэлтийн талбай
 - 17.2.3. Гимнастик, хөнгөн атлетик
 - 17.2.4. Сагсан бөмбөгийн талбай байна.



Зураг 17.1. Биеийн тамирын жишиг талбай

- 17.3. Биеийн тамирын талбай нь резин эсвэл хатуу хучилттай, хөл бөмбөгийн талбай нь зүлэг байх нь ашиглалтад тохиромжтой байдаг (БД 31-111-11, 3.8).
- 17.4. Биеийн тамирын талбайг төлөвлөхдөө сургуулийн хүчин чадалд суурилан тооцох бөгөөд эдэлбэр газрын хэмжээ, сургалтын онцлогтой уялдуулан гадна тохижилтын талбайг сонгоно.
- 17.5. Ерөнхий боловсролын сургуулийн хүчин чадалд суурилан сургуулийн биеийн тамирын талбайн хувийн жинг тооцно (БНБД 30.01.04, 2.12), (БНБД 30.01.03, 13-р хавсралт). Талбайн хувийн жинг Хүснэгт 17.1-д суралцагчдын тоогоор үржүүлэн тооцоолов.

Хүснэгт 17.1. Биеийн тамирын талбайн хэмжээ

Суралцагчдын тоо	Биеийн тамирын талбай /м²/
120	240
120 - 500	1000
500 - 800	1600
800 -1100	2200
1100 -1600	3200
1600 - 2000	4000
2000-аас дээш	4000-дээш

18. БАЙГУУЛЛАГЫН НЭРИЙН ТЭМДЭГ, БАЙРШЛЫН МЭДЭЭЛЭЛ

- 18.1. Бүх шатны төрийн байгууллага үйлчилгээгээ иргэдэд ойлгомжтой, чирэгдэлгүй, шуурхай байдлаар тав тухтай орчинд үзүүлэх нөхцөл боломжийг онцгойлон анхаарч үйл ажиллагаа явуулж байгаа барилгын гадна талд байгууллагын нэрийн тэмдгийг байршуулна.
- 18.2. Ерөнхий боловсролын сургуулийн гадна хаягийг “Төрийн байгууллагын нэрийн тэмдэг, байрлуулах удирдамж” UCS 2101A-ийн дагуу хийж байрлуулна. Байгууллагын нэрийн тэмдгийн загвар, хэмжээнд тавигдах шаардлагыг Зураг 18.1 -т үзүүлэв.

Байгууллагын төрөл: Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, Улаанбаатар хотын захирагчийн харьяа байгууллага, Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллагууд;

Самбар: Хөх цэнхэр өнгөтэй


Бичвэр: Цагаан өнгөтэй

Материал: Нерж материалтай



Зураг 5.1. Байгууллагын нэрийн тэмдэг

- 18.3. Байгууллагын нэр байршлын мэдээллийн самбарыг “Хотын стандарт - Мэдээллийн самбар” UCS 1401C -ийн дагуу хийж барилгын гадна талд гол хаалганы ойролцоо, барилгын дотор талд угтах үйлчилгээний хэсэг мөн цахилгаан шатны хэсэгт байрлуулна.
- 18.4. Самбарын бичвэр нь харагдахуйц, гаргацтай, өөрөөсөө буюу гаднаас гэрэлтүүлэгтэй, аудио болон дүрст видео төхөөрөмжөөр тоноглогдсон байж болно. Самбарын жишиг загварыг Зураг 18.2 -т үзүүлэв.



Зураг 18.2. Байгууллагын мэдээллийн самбар

19. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН НЭРИЙН БИЧВЭР

- 19.1. Ерөнхий боловсролын сургууль нь гадна хана, дээврийн хэсэгт өөрийн нэрийг том хэмжээгээр бичих буюу биет хэлбэрээр байрлуулж болох бөгөөд нэрийн бичвэрт “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283 болон “Байгууллагын нэрийн тэмдэг, нэрийн бичвэр байрлуулах удирдамж” UCS 2101A -ийг мөрдлөг болгоно (Зураг 19.1).
- 19.2. Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд иж бүрэн тохижилт хийж байгаа тохиолдолд нэрийн бичвэрийг сургуулийн орох хаалганы дэргэд архитектурын нэмэлт байгууламж болгон байрлуулж болно.

- 19.3. Барилгын гадна талд байрлуулах байгууллагын нэрийн бичвэрийг “Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай” (Монгол улсын Засгийн газрын 2013 оны 37-р тогтоол) тогтоолын дагуу Монгол хэл /кирилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих бөгөөд Монгол бичиг /уйгуржин/-ээр бичиж болно.
- 19.4. Шаардлагатай тохиолдолд байгууллагын нэрийн бичвэрийг англи хэлээр бичиж болох бөгөөд англи хэл дээрх бичвэр нь монгол бичвэрийн доод талд байрлаж, түүнээс 2 дахин бага өндөртэй байх, эсхүл Монгол /кирилл/ бичвэрийн зүүн гар талд байрлаж, түүнтэй ижил өндөртэй байна.



Зураг 19.1. Байгууллагын нэрийн бичвэрийн жишээ

- 19.5. Гадна хаягийн байгууламжийн бичвэрийг Засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын 5 дахь заалтын дагуу Монгол хэл /кирилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих бөгөөд Монгол бичиг (уйгуржин)-ээр бичиж болно.
- 19.6. Гадна талд байрлуулсан нэрийн бичвэр нь гадна талаасаа аль эсвэл дотор талаасаа гэрэлтүүлэгтэй байж болно.
- 19.7. Байгууллагын нэрийн бичвэрийг байрлуулахдаа цахилгаан болон барилга угсралтын аюулгүй ажиллагааны талаарх холбогдох норм, стандартыг баримтлах ба байрлуулахдаа бичвэр нь тухайн барилга болон хөрш зэргэлдээ объектын цонх, хаалга, үзэгдэх орчныг халхлахгүй байна
- 19.8. Нэрийн бичвэр нь барилгын үндсэн хийц, бүтээц, гадна фасадын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байхын зэрэгцээ хууль ёсны эзэмшигч, ашиглагч нараас албан ёсоор зөвшөөрөл авсан байна.
- 19.9. Байгууллагын нэрийн бичвэр нь утга төгөлдөр, ойлгогдохуйц, өнгө дизайн сайтай, хотын үзэмжид нийцсэн, орчин үеийн технологийн шийдлийг ашигласан байх бөгөөд ашиглагч байгууллагын зүгээс арчилгаа засвар, үйлчилгээг хийж, өнгө үзэмж бүрэн бүтэн байдлыг тогтмол хангуулна.

20. ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ХАЯГИЙН ТЭМДЭГ

- 20.1. Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд байрлаж байгаа гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг “Хаягжуулалтын тухай хууль”, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам” (Монгол улсын Засгийн газрын 2019 оны 325 -р тогтоол) -ийн хүрээнд хаягжуулна (Зураг 20.1).



Зураг 20.1. Байгууллагын нэрийн тэмдэг, барилгын үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэг

20.2. Хаяг гэж Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, батлагдсан газар зүйн нэр бүхий газар нутаг, хот, суурин газар дахь гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн байршлыг тодорхойлсон үсэг, тооны илэрхийллийг ойлгох бөгөөд үл хөдлөх эд хөрөнгө Хүснэгт 20.1-д заасан хаягийн иж бүрдлийн дагуу хаяг авч, бүртгэгдсэн байна.

Хүснэгт 20.1. Хаягийн иж бүрдэл

№	Хаягийн иж бүрдэл	Нийслэлд /Жишээ/
1	Улс:	Монгол Улс
2	Аймаг, нийслэл:	Улаанбаатар
3	Дүүрэг:	Чингэлтэй
4	Хороо:	1 (хороо)
5	Шуудангийн бүсчлэлийн код:	15170
6	Гудамжны нэр:	Худалдааны
7	Үл хөдлөх эд хөрөнгө /хашаа, барилга байгууламж/	0038

Хаягийг Монгол хэлний тухай хууль, Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, Кирилл монгол бичгийн дүрэм, “Монгол бичгийн цагаан толгой” MNS 4333, “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS 5283 болон “Барилга байгууламжийн хаяг, хаягийн тэмдэг байрлуулах удирдамж” UCS 2102A -ийг мөрдлөг болгоно.

20.4. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуулийн үл хөдлөх эд хөрөнгөд хаягийн иж бүрдэл бүхий хаягийн тэмдгийг шаардлагын хийж үл хөдлөх эд хөрөнгийн гадна талд байрлуулна (Зураг 20.2).

Дэлгэрэнгүй: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо Худалдааны гудамж, 15170-0038	Хураангуй: Худалдааны гудамж 15170-0038, 23 дугаар сургууль
---	--

Зураг 20.2. Төрийн байгууллагын хаягийн тэмдэг

- 20.5. Хаягийн тэмдгийн материал нь (30/50) мм-ийн зузаантай, байгалийн үзэгдэлд тэсвэрлэхүйц, зэвэрдэггүй металл эсвэл хамгаалалтын гадаргуутай байна (MNS 5283, 6.1.2 заалт), (Зураг 20.3).
- 20.6. Хаягийн тэмдгийн өнгө нь байгалийн аливаа үзэгдэлд хуурч гандахгүйгээс гадна шөнийн цагт харагдахуйц, тээврийн хэрэгслийн болон бусад төрлийн гэрлийн тусгалаар гэрэлтдэг материалаар хийнэ (MNS 5283, 6.1.3 заалт).



Зураг 20.3. Барилгын үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэг

21. ХОГ ХАЯГДАЛ ТҮР ХАДГАЛАХ ЦЭГ

- 21.1. Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1.3–д заасны дагуу иргэн аж ахуйн нэгжүүд хог хаягдлыг хаяхдаа ангилан ялгах үүрэгтэй бөгөөд ялгах таних тэмдгийг зөв ашиглах нь дахин боловсруулах үйл ажиллагаанд чухал үүрэгтэй.
- 21.2. Сургуулийн хог хаягдал түр хадгалах цэг нь хана, хашаагаар тусгаарласан хаалттай, битүүмжлэл сайтай, хог ангилж хийх боломжтой, сургуулийн барилга байгууламжаас 30 метрээс, усны эх үүсвэрээс 100 метрээс багагүй зайд зонхилох салхины доод зүгт байрлана (MNS 6782:2019, 5.6).
- 21.3. Хог хаягдал түр хадгалах цэг рүү орох хог ачих зориулалт бүхий тусдаа орц гарцтай байхаар төлөвлөнө (Зураг 21.1).
- 21.4. Хог хаягдал цуглуулах цэгт байх хогийн саванд хог хаягдлыг ангилан хаях бөгөөд ангиллын дагуу өнгө, тэмдэг, тэмдэглэгээтэй байна.



Зураг 21.1. Хог хаягдал цуглуулах цэг

21.5. Хог хаягдал цуглуулах савнууд нь цаасан дахивар болон бусад хог хаях зориулалтыг заасан олон улсад хэрэглэгддэг мэдээлэх тэмдэгтэй байх ба хог хаягдлыг ангилах, ачих, цуглуулах технологид нийцсэн байх шаардлагатай (Зураг 21.2).




Зураг 21.2. Ангилан ялгах тэмдэг бүхий хогийн сав

- 21.6. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага (Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаал)-ын дагуу ангилж, MNS 5344:2011 стандартын дагуу тээвэрлүүлнэ.
- 21.7. Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ (Хог хаягдлын тухай хууль 14.6).
- 21.8. Хог ачих талбай тэгш гадаргуутай, хонхор гүдгэргүй, хучилттай, автомашин ба механизм эргэх, тойрох, өргөх хөдөлгөөн хийхэд саадгүй байлгана (MNS 5344:2011, 7.3).

22. НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЗАМ, ТАЛБАЙН ГЭРЭЛТҮҮЛЭГ


- 22.1. Гэрэлтүүлэг нь хот суурин газар, барилга байгууламжийн орчны өнгө төрхөд ихээхэн нөлөөлдөг учраас зураг төсөл гүйцэтгэхээс эхлүүлэн архитектор дизайны үзэл баримтлалтайгаар төлөвлөнө.
- 22.2. Гэрэлтүүлгийн төрөл ангилал, ган багана, өнгө, суурьлуулах техник зэргийг Монгол улсын үндэсний стандарт “Гэрэлтүүлгийн ган багана. Техникийн шаардлага” MNS2568 болон “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд байршуулах гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавигдах шаардлага” UCS 1901B -ийг мөрдлөг болгоно.
- 22.3. Гэрэлтүүлэг нь шөнийн цагаар замын хөдөлгөөний ослын эрсдэлийг бууруулах, гэмт хэргийг таслан зогсоох, барилга, эд хөрөнгийг хамгаалах, орчны аюулгүй байдлыг хангах, хорлон сүйтгэх үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, орчны өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зэрэг чухал үүрэг гүйцэтгэдэг.
- 22.4. Гэрэлтүүлгийн ган баганыг суурилуулахдаа гудамжны ногоон байгууламжийн мод, бутны хэмжээ, тэдгээрийн байршил, ургалтын хэв маягийг анхаарах шаардлагатай.
- 22.5. Гудамжны архитектур, гоо зүйг бий болгох үүднээс гэрэлтүүлэг, гэрэлтүүлгийн шон, толгой, хүзүү нь гудамжны бусад тавилгатай өнгө, загвар, дизайны уялдаатай, нэгдсэн хослол байх ёстой (Зураг 22.1).



Зураг 22.1. Гадна орчны гэрэлтүүлэг

23. ХЯНАЛТЫН КАМЕРЫН СИСТЕМ

- 23.1. Сургуулийн гадна болон дотор орчинд багш, албан хаагчид, сурагчдын аюулгүй байдлын хэрэгцээ, хувийн болон нийтийн өмч хөрөнгийг хамгаалан аюулгүй байдлыг хангаж, гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай.
- 23.2. Хяналтын камерын системийг суурилуулж байнгын видео тандалт хийх нь аюулгүй байдлыг хангах, хамгаалах хамгийн үр дүнтэй аргын нэг бөгөөд энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ хувь хүний нууцыг хадгалж тэдний эрхийг зөрчихгүй байхад онцгойлон анхаарах нь чухал.
- 23.3. Хяналтын камер байршуулсан газруудад таних тэмдгийг байршуулах шаардлагатай бөгөөд олон улсад хэрэглэгддэг тэмдэглэгээг ашиглана (Зураг 23.1).




Зураг 23.1. Хяналтын камер тэмдэг

- 23.4. Дууны, дүрсний, мэдээллийг цуглуулах, хадгалах, ашиглах боломж бүхий хөдөлгөөнт болон суурин дүрс бичлэгийн техник, хэрэгсэл нь Монгол Улсын “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, Ерөнхий шаардлага /MNS 6423:2013/, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.6 -т заасан шаардлага болон олон улсын “IP67 стандарт” -д нийцсэн байна.
- 23.5. Сургуулийн орчмын бүсэд хөдөлгөөний аюулгүй байдлыг хянах, мэдээлэх зорилгоор MNS 6423:2019 стандартын шаардлагыг хангасан теле хяналтын камерыг MNS 6444:2014 стандартын дагуу суурилуулна.

24. ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ


- 24.1. Сургуулийн бүсэд авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахдаа хөдөлгөөний эрчим ихтэй замаас тусгаарлан, сургуулийн бүсэд орох орц гарцыг зохистой байрлалд төлөвлөнө.
- 24.2. Сургуулийн бүсэд байрлах авто замд Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, холбогдох дүрэм, стандартад заасны дагуу тэмдэг, тэмдэглэгээ, хэрэгслийг заавал суурилуулна.
- 24.3. Сургууль орчмын авто зам, талбай, авто зогсоол, гарц гарамтай хэсэгт замын хөдөлгөөний дүрэм, болон (MNS 4596 :2014), (MNS 6444 :2014), (MNS 5968:2009) гэх зэрэг стандартад заасны дагуу хэвтээ болон босоо тэмдэг, тэмдэглэгээг бүрэн бүтэн байршуулж, хүүхдийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана (MNS 6782:2019)




Зураг 24.1. Сургууль орчмын бүсийн замын хөдөлгөөн, тэмдэг тэмдэглэгээ


24.4 Сургуулийн бүсийн ойр орчмын замд тээврийн хэрэгслийн хурд, хөдөлгөөний журмыг зохицуулах аюулгүй орчныг бүрдүүлэх, замын хөдөлгөөнд оролцогчийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, ослоос үүдэн гарах хохирлыг багасгах зорилгоор Хүснэгт 24.1-т тусгасан авто замын тэмдгийг суурилуулна.

Хүснэгт 24.1. Сургуулийн бүсэд суурилуулах авто замын тэмдэг


 Сургууль орчмын бүс 5.25	Сургууль орчмын бүс дотор тогтоосон хөдөлгөөний журмыг баримтлах нутаг дэвсгэрийг мэдээлнэ. Уг нутаг дэвсгэр рүү орох хэсэг бүрийн шууд өмнө байрлуулна. (MNS 4596:2014) Сургуулийн бүсээс өмнө дор хаяж 200 мм-ийн наана байрлуулна. (MNS 6444:2014)
 Сургууль орчмын бүсийн төгсгөл 5.26	5.25 тэмдгээр тэмдэглэсэн нутаг дэвсгэр (замын хэсэг)-ээс гарч байгааг мэдээлэхэд хэрэглэнэ. (MNS 4596 :2014) Сургууль орчмын бүс доторх огтлолцсон зам төгсөхөд (5.25, 5.26) тэмдгийг сургуулийн бүсэд тууш зам дээр Т хэлбэрийн уулзварын төгсгөлийн эсрэг талд байрлуулна (MNS 6444 :2014).
 Явган хүний гарц 5.19	5.19.а, 5.19.б «Явган хүний гарц» тэмдгүүдийг зорчих хэсгээр явган зорчигч хөндлөн гарахад зориулсан газрыг мэдээлэхэд хэрэглэнэ. 5.19.а тэмдгийг замын зүүн гар талд, 5.19.б тэмдгийг баруун гар талд байрлуулна. Тэмдэглэлтэй гарц дээр 5.19.а, 5.19.б тэмдгийг тухайн гарцын хилээс 1 м-ээс холгүй зайд байрлуулна (MNS 4596 :2014).
 Хурд сааруулагч 5.18	Тээврийн хэрэгслийн хурдыг сааруулах зориулалт бүхий хиймэл бартааг мэдээлнэ. Хурд сааруулагчийн өмнө байрлуулна (MNS 5968:2009).
 Хурд сааруулагч 1.17	Зорчих хэсэг дээр тээврийн хэрэгслийн хурдыг сааруулах зориулалт бүхий хиймэл бартаа байгааг анхааруулна. Хурд сааруулагч тавигдсан газраас 50-100 метрт байрлуулна (MNS 5968:2009).
 Хурдны хязгаар 2.24	Сургуулийн бүс дэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг ерөнхий боловсролын болон тусгай сургууль, цэцэрлэг ажиллах өдрүүдэд, цагт 20 км/ц-ээс хэтрүүлэхгүй байна (MNS 6444 :2014). 2.24 тэмдгүүдийн үйлчлэх хүрээ нь байрласан газраасаа эхний уулзвар хүртэл, уулзваргүй замд суурин газраас гарах хүртэл хүчинтэй байна. (МУЗХД)

1.19  Хүүхэд 1.19	Зорчих хэсэг рүү хүүхэд гэнэт орж ирж болзошгүй хэсгийг анхааруулна. Замын зэргэлдээх сургуулийн орчны дэргэдүүр явж өнгөрөх замын хэсгийн өмнө болон бага насны хүүхдүүд байнга зам хөндлөн гардаг хэсгийн өмнө явган хүний гарц байгаа эсэхээс үл хамааруулан байрлуулна (MNS 6444 :2014).
 Нэмэлт тэмдэг 7.2a	1.19 тэмдгийг давтан тавьж хэрэглэнэ. Давтан тавих тэмдгийг 7.2.a нэмэлт тэмдгийн хамт аюултай хэсгийн эхлэлийн шууд өмнө байрлуулах бөгөөд уг нэмэлт тэмдгээр тухайн хүүхдийн байгууллагын орчны дэргэдүүр явж өнгөрсөн замын хэсэг буюу хүүхдүүд байнга зам хөндлөн гардаг хэсгийн үргэлжлэх зайг заана (MNS 6444:2014).
1.20  Унадаг дугуйн зам нийлнэ 1.20	Унадаг дугуйн замтай огтлолцсон хэсэгт ойртож байгааг анхааруулна. 1.20 тэмдгийг 4.4 тэмдэг бүхий унадаг дугуйн зам (уулзвараас өөр хэсэгт) зорчих хэсэгтэй огтлолцсон бэлчрийн өмнө байрлуулна (MNS 6444 :2014).
4.4  Унадаг дугуйн зам 4.4	Зөвхөн унадаг дугуй, мопедын хөдөлгөөнийг зөвшөөрөхөөс гадна Замын хөдөлгөөний дүрмийн 5.1-д заасны дагуу явган зорчигчийн хөдөлгөөнийг мөн зөвшөөрнө.

24.5 Замын тэмдгийг байрлуулах, суурилуулахдаа замын зорчих хэсгээс 0.5-2м, 2-4м өндөртэй суурилуулна (MNS 4596:2014). Суурилуулах зааврыг Зураг 24.2-т тусган харуулав.



Зураг 24.2. Замын босоо тэмдэг суурилуулах



Зураг 24.2. Сургуулийн бүс дэх хурд сааруулагч

24.6. Тодорхой хэсэг газарт замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн хурд хэтрүүлэхээс сэргийлэн тухайн бүс нутгийг дайран өнгөрөх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурдыг хязгаарлах зорилгоор хурд сааруулагчийг байршуулна. Явган хүний гарцаас 3000мм зайтай байна (MNS 5968:2009). Хурд сааруулагчийн өндөр 70мм, өргөн нь 4200 мм, урт нь зорчих хэсгийн өргөнтэй тэнцүү байна (Зураг 24.1).


25. ГАМШГААС ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

25.1. Сургуулийн барилга нь багш, албан хаагч, суралцагчдын эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахгүй, бат бэх тогтвортой, галын аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хор хөнөөлийг хязгаарлах нөхцөлийг хангана (MNS 6782:2019).

25.2. Барилга байгууламж, тээврийн хэрэгсэл гал түймэр унтраах анхан шатны багаж, хэрэгслээр хангагдсан байна. Анхан шатны багаж, хэрэгслийг өөр зориулалтаар ашиглахыг хориглоно (Галын аюулгүй байдлын тухай хууль 19.3), (Хүснэгт 25.1).

Хүснэгт 25.1. Гал унтраах анхан шатны багаж

 Галын дохиолол	 Ослын гарц
---	---




Сургуулийн барилга байгууламж нь цахилгаан хангамж, эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй байх бөгөөд аянга зайлуулагч газардуулгатай байна (MNS 6782:2019).

25.4. Сургуулийн барилгын дээвэр болон сургуулийн орчинд харилцаа холбооны антен, тоног төхөөрөмж байрлуулахыг хориглоно (MNS 6782:2019).



Зураг 25.1. Сургуулийн бүсэд байрлах цугларах талбай

25.5. Болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор нийслэлийн нутаг дэвсгэрт гамшгийн үед түр цугларах цэгийг гадна талбайд төлөвлөнө. Сургуулийн бүсэд цугларах талбай нь сургуулийн амрах талбай байж болох бөгөөд Зураг 25.1-т, цугларах талбайн таних тэмдгийг Зураг 25.2-д үзүүлэв.



Зураг 25.2.6 Түр цугларах аюулгүй талбай тэмдэг, суурилуулах схем

26. АЖ АХУЙН БҮС

- 26.1. Аж ахуйн бүсэд зоорь, худаг, уурын зуух, под станц, гарааш, авто зогсоолтой тохиолдолд тухайн бүсэд нэвтрэхийг хориглосон болон аюултай болохыг анхааруулсан тэмдэг, тэмдэглэгээтэй, хүүхэд авирах, шургах боломжгүй байхаар төлөвлөнө (MNS 6782:2019).
- 26.2. Зам нь хатуу хучилттай, 20 тонны даацтай галын машин зорчих боломжтой байх ба 1 орцыг аж ахуйн зориулалтаар ашиглахаар тооцно (БД 66-88, 5.6).
- 26.3. Аж ахуйн зориулалттай бүсийг суралцагчдын тоотой уялдуулан эдэлбэр газарт төлөвлөнө (БНБД 30.01.04, 2.12), (БНБД 30.01.03, 13-р хавсралт). Талбайн хэмжээг Хүснэгт 26.1-т үзүүлэв.

Хүснэгт 26.1. Аж ахуйн бүсийн талбайн хэмжээ

Суралцагчдын тоо	Аж ахуйн зориулалтын талбай /м²/
120	36
120 - 500	150
500 - 800	240
800 - 1100	330
1100 - 1600	480
1600 - 2000	600
2000-аас дээш	600-дээш

27. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчны төлөвлөлтийн шаардлага хангаж байгаа эсэхийг хүлээн авах шалгуур үзүүлэлтийг Хүснэгт 1 -ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Сургуулийн эдэлбэр газрын хэмжээ стандарт, норм дүрмийн шаардлагад хүрч байгаа эсэх	☐	☐
2	Сургуулийн барилгын гол хаалга, гадна довжоо хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй байдлыг хангаж байгаа эсэх	☐	☐
3	Сургуулийн эдэлбэр газрын хашаа (зай, хэмжээ, өнгө, суурилуулалт) стандартын шаардлага хангаж байгаа эсэх	☐	☐
4	Сургууль орчмын бүс гэсэн тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу хийсэн эсэх	☐	☐
5	Стандартын дагуу теле хяналтын камер суурилуулсан эсэх	☐	☐
6	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй байдлын шаардлага хангасан эсэх	☐	☐
7	Барилга байгууламжийн нэрийн бичвэр, үл хөдлөх хөрөнгийн хаяг, хаягийн байгууламж нь (зай, хэмжээ, үзэгдэх орчны нөлөө, суурилуулалт) шаардлага хангасан эсэх	☐	☐
8	Явган хүний зам стандартын шаардлага хангаж байгаа эсэх (материалын чанар, зай хэмжээ, замын суурь, бэхэлгээ)	☐	☐
9	Унадаг дугуйн зам болон зогсоол нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх (замын хучилт, өнгө, тэмдэглэгээ, зай хэмжээ)	☐	☐
10	Ногоон байгууламж стандартын шаардлага хангаж байгаа эсэх (ногоон байгууламжийн газрын хэмжээ, ногоон байгууламжийн төрөл зүйл, хар хөрсний хэмжээ)	☐	☐
11	Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх (саравч, сүүдрэвч, сандал, хогийн саванд тавигдах шаардлагын дагуу)	☐	☐
12	Биеийн тамирын талбай стандартын шаардлага хангаж байгаа эсэх (талбай тус бүрийн материалын чанар, суурилуулалт бэхэлгээ, зай хэмжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны заавар, тэмдэг тэмдэглэгээ)	☐	☐
13	Авто зогсоолын талбай нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх (замын хучилт, замын суурь, хөдөлгөөний аюулгүй байдлын тэмдэг, тэмдэглэгээ, зай хэмжээ, нэмэлт тоноглол, орц гарц)	☐	☐
14	Хог хаягдал цуглуулах цэг нь стандартын шаардлага хангаж байгаа эсэх (хог цуглуулах сав, ачих талбай, орц гарц, зай хэмжээ)	☐	☐
15	Аж ахуйн бүстэй бол түүнд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэх	☐	☐

Тайлбар:

- Ерөнхий боловсролын сургуулийн төлөвлөлт нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.
- Бусад тохижилт бүтээн байгуулалтад хамаарах зүйлсийг Хотын стандартын баримт бичгийн тогтолцоонд хамаарах хүлээн авах шалгуурын дагуу шалгаж хүлээн авна.





АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

28. Монгол Улсын үндсэн хууль
29. Биеийн тамир, спортын тухай хууль;
30. Хог хаягдлын тухай хууль;
31. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
32. Галын аюулгүй байдлын тухай хууль;
33. Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм;
34. Монгол Улсын барилгын дүрэм. Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлтийн дүрэм /Зам тээвэр барилга хот байгуулалтын сайдын 2011 оны 305 дугаар тушаал/;
35. Сургалт хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм /Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны А/179 дүгээр тушаал/;
36. Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаал/;
37. Гадна зар сурталчилгаанд тавих шаардлага /Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 9/10 дугаар тогтоол/;
38. БНБД 3.01.06-90 Барилгын орчны тохижилт
39. БНБД 30-01-04 Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм
40. БНБД 32-04-06 Хот тосгоны гудамж, зам төлөвлөлт
41. БД 31-111-11 Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт
42. БНБД 21-05-10 Авто зогсоол
43. БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм
44. ЗЗБНБД 31-008-2016 Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын жишиг техникийн шаардлага
45. БД 43-101-03 Монгол улсын цахилгаан тоног төхөөрөмжийн байгууламжийн дүрэм
46. БД 30-102-11 Хот тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх
47. БНБД 23-02-08 Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг
48. MNS 2568:1983 Гэрэлтүүлгийн ган багана техникийн шаардлага
49. MNS 6782:2019 Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
50. MNS 6444:2014 Сургуулийн бүс. Техникийн ерөнхий шаардлага
51. MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
52. MNS 4597:2014 Авто замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага
53. MNS 4759:2014 Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага
54. MNS 5342 : 2007 Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага

55. MNS 5025 : 2020 Авто үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага
56. MNS 6808:2019 Явган хүний зам талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага
57. MNS 4980:2014 Авто замын гэрлэн дохио. Техникийн ерөнхий шаардлага
58. MNS 5682:2006 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам. Техникийн шаардлага
59. MNS 6056:2009 Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар
60. MNS 5683:2006 Дугуйтай зорчигчийн зам. Техникийн шаардлага
61. MNS 5342:2007 Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага шон. Техникийн шаардлага
62. MNS 5968 : 2009 Хурд сааруулагч. Техникийн ерөнхий шаардлага. Хэрэглэх дүрэм
63. MNS 5344:2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавигдах ерөнхий шаардлага
64. MNS 5420-18:2004 Боловсрол. Биеийн тамирын боловсрол
65. MNS 6423:2019 Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага
66. MNS 6542:2015 Хөл бөмбөгийн спортын орчин болон сургалтад тавих шаардлага
67. MNS 3736:2010 “Хамгаалалтын төмөр бетон хашаа. Техникийн шаардлага”
68. MNS ASTM D 1241: 2002 Явган хүний замын хучилтын суурийн материал
69. MNS 6775:2019 Хаяг. Хаягийн бичвэрт тавигдах шаардлага
70. MNS 5283:2014 Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага
71. UCS 0001-02:2019 Иж бүрэн гудамж
72. UCS 0901B:2020 Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт угсралтад тавигдах шаардлага
73. UCS 0903B:2020 Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавигдах шаардлага
74. UCS 0902B:2020 Тээврийн хэрэгслийн ил зогсоолыг төлөвлөх, байгуулахад тавигдах ерөнхий шаардлага
75. Түлш унтрахаас өмнө буюу дөлтэй үед түлшээ нэмнэ.

36

ХАВСРАЛТ 2. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ГАДНА ОРЧНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ СХЕМ ЗУРАГ





Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж -7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



7011-8060



www.standart.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар